



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 12 сарын 22 өдөр

Дугаар А/240

Улаанбаатар хот

Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжсэнтэй холбогдуулан авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5."в", 29.1.6."а", "ж", "л", 29.2, 30 дугаар зүйлийн 30.1.6, 39 дүгээр зүйл, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.7, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.5 дугаар зүйл, Засгийн газрын 2020 оны 226 дугаар тогтоол, Улсын Онцгой комиссын 2020 оны 39 дүгээр хурлын тэмдэглэл, Нийслэлийн Онцгой комиссын 2020 оны 23 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Нийслэлийн нутаг дэвсгэрт Коронавируст /Ковид-19/ цар тахлын халдварын тархалтыг хязгаарлах зорилгоор "Бүх нийтийн бэлэн байдлын зэрэг"-т хэсэгчилсэн байдлаар шилжүүлсэн хугацаанд хязгаарлалт тогтоохгүй төрийн байгууллага, хуулийн этгээдийн үйл ажиллагааны жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2.Иргэдийн зорчилт, хөдөлгөөний хязгаарлалтыг мөрдүүлж, зайлшгүй шаардлагатай хөдөлгөөний мэдээллийг QR системд бүртгэх ажиллагааг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг нийслэлийн Инноваци, технологийн асуудал хариуцсан төслүүдийн удирдагч /Д.Ихбаяр/, дүүргийн Засаг дарга нар, нийслэлийн Цагдаагийн удирдах газар /Ш.Цогбаатар/, нийслэлийн Онцгой байдлын газар /Л.Баярсайхан/-т үүрэг болгосугай.

3.Хязгаарлалт тогтоохгүй хуулийн этгээдийн ажилтан, албан хаагчдын тээврийн хэрэгслийг хөдөлгөөнд оролцуулж, хяналт тавих асуудлыг зохион байгуулахыг нийслэлийн Зам, тээврийн асуудал хариуцсан төслүүдийн удирдагч /Б.Одсүрэн/, нийслэлийн Мэдээлэл, технологийн газар /О.Чинзориг/, нийслэлийн Замын хөдөлгөөний төлөвлөлт, зохицуулалт, инженерчлэлийн газар /С.Энхтөр/, Тээврийн Цагдаагийн албаны Замын Цагдаагийн газар /Д.Дашдорж/-т үүрэг болгосугай.

4.Нийтийн тээврийн үйлчилгээг тусгай горимд шилжүүлж, халдвар хамгааллын дэглэмийг мөрдүүлж ажиллахыг нийслэлийн Нийтийн тээврийн үйлчилгээний газар /Ч.Сайханбаяр/-т үүрэг болгосугай.

5.Улаанбаатар хотын авто тээврийн шалган нэвтрэх товчоодын хөдөлгөөнд хязгаарлалт тогтоож, энэ захирамжийн хавсралтад дурдсан 1, 2, 3, 4, 5, 7, 8, 11, 12-т заасан үйлчилгээ эрхлэгч, жолооч, зорчигчдын PCR шинжилгээний хариуг үндэслэн, халдвар хамгааллын дэглэмийг мөрдүүлж гаргах, маршрутын бус замын хяналтыг чангатгаж ажиллахыг нийслэлийн Эрүүл мэндийн газар /Л.Төмөрбаатар/, нийслэлийн Онцгой байдлын газар /Л.Баярсайхан/, нийслэлийн Цагдаагийн удирдах газар /Ш.Цогбаатар/, нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар /Л.Эрдэнэчулуун/, Тээврийн Цагдаагийн албаны Замын Цагдаагийн газар /Д.Дашдорж/, нийслэлийн Мал эмнэлгийн газар /А.Нарантуяа/-т, дүүргийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

111020006445

6.Халдварын тохиолдол бүртгэгдсэн байршилд иргэдийн хөдөлгөөнийг хязгаарлаж, халдваргүйжүүлэлт хийх, хэв журам, аюулгүй байдлыг сахиулан, хүн хүч, техник хэрэгслийн нөөцийг шуурхай бүрдүүлж ажиллахыг нийслэлийн Эрүүл мэндийн газар /Л.Төмөрбаатар/, нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар /Л.Эрдэнэчулуун/, Нийслэлийн Онцгой байдлын газар /Л.Баярсайхан/, нийслэлийн Цагдаагийн удирдах газар /Ш.Цогбаатар/, дүүргийн Засаг дарга нар, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба /Т.Гантөмөр/-нд үүрэг болгосугай.

7.Нийслэлийн нутаг дэвсгэрийн хэмжээнд гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлсэнтэй холбогдуулан төрийн болон нутгийн захиргааны байгууллагын ажилтан, албан хаагчдын 10-15 хүртэлх хувийг ажлын байранд, бусад ажилтан албан хаагчдыг гэрээсээ цахимаар ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлж ажиллахыг байгууллагуудын удирдлагуудад зөвлөсүгэй.

8.Иргэн, хуулийн этгээдээс ирсэн лавлагаа, мэдээлэл, санал хүсэлтийг 24 цагаар хүлээн авч, шуурхай шийдвэрлэж ажиллахыг нийслэлийн Онцгой комиссын “Шуурхай штаб”, дүүргүүдийн Онцгой комисст тус тус үүрэг болгосугай.


9.Хүнсний худалдааны үйл ажиллагаа явуулах цагийн хязгаарыг 07:00-22:00 цаг хүртэл хугацаагаар тогтоож, согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдэд спиртийн өндөр агууламж /18 хувиас дээш/ бүхий согтууруулах ундаа худалдахыг хориглосугай.

10.Коронавируст /Ковид-19/ цар тахлын халдварын тархалтыг хязгаарлах зорилгоор зохион байгуулж, хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа, заавар, зөвлөмжийг иргэд, олон нийтэд шуурхай мэдээлж ажиллахыг нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хэвлэл мэдээлэлтэй харилцах хэлтэс /Б.Батманлай/, нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын удирдлагуудад үүрэг болгосугай.

11.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг нийслэлийн Засаг даргын Хөгжлийн бодлогын асуудал хариуцсан нэгдүгээр орлогч /Ж.Сандагсүрэн/-д даалгасугай.

12.Энэ захирамж гарсантай холбогдуулан нийслэлийн Засаг даргын 2020 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн “Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэргийг бууруулсантай холбогдуулан хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” А/1280 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧИ



Д.СУМЪЯАБАЗАР

Нийслэлийн Засаг даргын 2020 оны
12 дугаар сарын 22 өдрийн
Захирамжийн хавсралт



ХЯЗГААРЛАЛТ ТОГТООХГҮЙ ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА,
ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖАГСААЛТ

№	ҮЙЛ АЖИЛЛАГАА
1.	Цахилгаан, дулаан, сайжруулсан түлшээр хангах үйл ажиллагаа
2.	Хүнсний үйлдвэрлэл, хүнс, ахуйн хэрэглээний барааны худалдаа, түгээлт, тээвэрлэлт, сав баглаа боодлын үйлдвэрлэлийн үйл ажиллагаа
3.	Газрын тосны бүтээгдэхүүн, түлшний хангамж, түгээлт, тээвэрлэлтийн үйл ажиллагаа
4.	Мал, амьтны өвс, тэжээлийн түгээлт, тээвэрлэлтийн үйл ажиллагаа
5.	Улсын онц чухал болон стратегийн ач холбогдол бүхий объект, байгууллага, тэдгээрийн хүч хэрэгслийн хангамж, тээвэрлэлтийн үйл ажиллагаа /Гадаадын дипломат төлөөлөгчийн газар, НҮБ-ын суурин төлөөлөгчийн газар, “Улаанбаатар төмөр зам” хувь нийлүүлсэн нийгэмлэг, “Иргэний нисэхийн ерөнхий газар”, “МИАТ” ТӨХК, “Чингис хаан” олон улсын нисэх буудал, “Биокомбинат” төрийн өмчит үйлдвэрийн газар, Стандарт, хэмжил зүйн газар, Үнэт металлын сорьцын хяналтын газар, Үндэсний дата төвийн нөөц төв/
6.	Нийтийн тээвэр, зөвшөөрөлтэй такси үйлчилгээ
7.	Хот, суурины усан хангамж, ариутгах, татуургын ашиглалт, хот тохижилт, хог хаягдлын үйлдвэрлэл үйлчилгээ, золбин нохой, муур устгал, орчны ариутгал, халдваргүйжүүлэлтийн үйл ажиллагаа
8.	Эрүүл мэндийн байгууллага, эм, эмнэлгийн хэрэгсэл ханган нийлүүлэх үйл ажиллагаа
9.	Банкны төлбөр тооцоо, эрх бүхий байгууллагын зөвшөөрөлтэй гэрээт харуул хамгаалалтын үйл ажиллагаа
10.	Хэвлэл мэдээлэл, харилцаа холбоо, шуудангийн үйл ажиллагаа /цагийн хязгаартай/
11.	Тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагын үйл ажиллагаа /Онцгой байдал, Мэргэжлийн хяналт, Цагдаа, Зэвсэгт хүчин, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, Гааль, Татвар, Агаарын бохирдол, Байгаль орчныг хамгаалах, Улсын бүртгэл, Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх, дипломат болон тусгай алба, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар/
12.	Оршуулгын үйл ажиллагаа
13.	Халамж, асрамжийн төв, гэр бүл, хүүхэд хамгааллын үйл ажиллагаа
14.	Хууль тогтоох дээд байгууллага, төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагаа
15.	Шүүх, прокурор, нотариат, өмгөөлөл /хязгаартай/ - ийн үйл ажиллагаа

Жич: Захирамжид тусгагдаагүй бусад харилцааг Коронавируст /Ковид-19/ цар тахалтай тэмцэх, хариу арга хэмжээг зохион байгуулах үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа хууль, дүрэм, журам, зааврын хүрээнд Нийслэл, дүүргийн Онцгой комиссын “Шуурхай штаб”-ууд тухай бүр шийдвэрлэж ажиллана.

